



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 1/168

Бор-Өндөр сум

**Засаг даргын нөөц хөрөнгөөс
хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр Тушаалын хавсралтаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4, 2.1.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын 1 дүгээр багт “Ариун цэврийн байгууламж” барих ажлын урьдчилгаа 50 хувийн санхүүжилт болох 7 871 120 (долоон сая найман зуун далан нэгэн мянга нэг зуун хорин) төгрөгийг зарцуулсугай.

2. Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулах 7 871 120 (долоон сая найман зуун далан нэгэн мянга нэг зуун хорин) төгрөгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (О.Мөнхцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.АДЪЯАБИЛЭГТ